

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1074

танай _____-ны № _____-т

Г Дүгнэлт хүргүүлэх тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох "Монголын хүний төлөө нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж, хуульд заасны дагуу хянуулан дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож дүгнэлт гаргалаа.

Дүгнэлт

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор "Монголын хүний төлөө нам"-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Монголын хүний төлөө нам"-ын мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan_Bichigt2024\0420 GNAG-3.Docx

0001030670



2024 ОНЫ
УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР




2024 оны 4-р сарын 1-ны өдөр

00000001

АГУУЛГА:

1. МХТН-ын үзэл баримтлал
2. Ерөнхий зүйл
3. Нийгэм, эрүүл мэнд, халамжийн бодлого
 - 3.1. Эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх, чийрэгжүүлэх
 - 3.2. Хүн амын өсөлт
 - 3.3. Ажилгүйдлийг бууруулах бодлого
 - 3.4. Нийгмийн халамж
4. Боловсрол, соёл, шинжлэх ухааны бодлого
 - 4.1. Ерөнхий боловсрол
 - 4.2. Мэргэжлийн сургалт
 - 4.3. Соёл
 - 4.4. Шинжлэх ухаан
 - 4.5. Спорт
5. Эдийн засаг үйлдвэрлэлийн бодлого
 - 5.1. Төсөв, санхүү
 - 5.2. Хөдөө аж ахуй
 - 5.3. Газар тариалан
 - 5.4. Аж үйлдвэр
 - 5.5. Уул уурхай
 - 5.6. Эрчим хүч
 - 5.7. Зам тээвэр, дэд бүтэц
 - 5.8. Барилга, хот байгуулалт
 - 5.9. Аялал жуулчлал
6. Төрийн байгуулалт, хууль зүйн бодлого
 - 6.1. Улс төрийн шинэчлэл
 - 6.2. Төрийн алба
 - 6.3. Засгийн газрын бүтэц, үүрэг
 - 6.4. Хяналтын тогтолцоо
 - 6.5. Шүүх засаглал
 - 6.6. Хүчний байгууллагын өөрчлөлт
7. Аюулгүй байдал, гадаад харилцааны бодлого
 - 7.1. Батлан хамгаалах
 - 7.2. Гадаад харилцаа
 - 7.3. Гадаад хөрөнгө оруулалт
 - 7.4. Гадаад худалдаа



A handwritten signature in black ink is located at the bottom center of the page.

1. МОНГОЛЫН ХҮНИЙ ТӨЛӨӨ НАМЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Монголын Хүний Төлөө Нам нь Монгол Улсдаа хүнлэг энэрэнгүй, хүн төвтэй, иргэний эрх зүйт нийгмийг цогцлоож, хуульт ёсыг дээдлэн, хөгжил дэвшилд манлайлж, иргэний хяналт бүхий төрийн тогтолцоог байгуулах эрхэм зорилгыг баримтална.

Иргэний хяналтын тогтолцоо нь төрийн албан хаагчдын сахилга бат, ёс зүй, төрийн болон нийтийн хөрөнгөний зарцуулалт, хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих арга, замаар хэрэгжинэ. Түүнчлэн,

Бид:

1-рт: Монгол Улсын үлэмж баялаг нь хүн **Та** хэмээн дээдэлнэ;

2-рт: Аливаа бодлогыг эрүүл агаар, эрүүл хүнс, эрүүл орчин, эрүүл эрх зүй, эрүүл нийгмийн шаардлаганд нийцүүлэн хэрэгжүүлнэ;

3-рт: Тулгар төрийг хүчирхэг, хяналттай, тогтвортой, алсын хараатай, хэтийн бодлогоор цогцлоон байгуулж, Монгол төрийн бахархалыг бүрдүүлнэ;

4-рт: Нийтийн эрх ашгаар хувийн эрх ашгийг хязгаарлаж, нийгмийн баялгийг шударга хуваарилан, олигархи бүтэглэлийн эрх мэдэл, хөрөнгө мөнгөний шунал тачаалыг хязгаарлан зогсоож, хөдөлмөрөө шударгаар үнэлүүлдэг бүтээлч, үйлдвэрлэгч үндэсний дундаж давхаргыг хүчирхэгжүүлнэ;

5-рт: Хүчтэй нь хүчгүйгээ захирдаг адгуусны хуулийг халж, соёлт нийгмийг оюун ухаан, амьдралын туршлагаараа залж удирдах, хөдөлмөр чадвараараа манлайлах, мэдлэг, боловсролоо дээдэлсэн, ёс зүйтэй, оюунлаг, нийгмийг цогцлоон байгуулна;

6-рт: Хууль цаазын өмнө хэн боловч тэгш эрхтэй байх зарчмыг хангах үүрэгтэй шүүхийн байгууллагыг шударга, тэнцвэртэй байлгах зорилгоор төр болон ард түмэн нь эрх мэдлээ хамтран хэрэгжүүлдэг шүүх байгууллагын сонгодог хувилбарыг нэвтрүүлж хэрэгжүүлнэ;

7-рт: Гадаадын аливаа этгээдтэй эрх тэгш, нөхөрсөг харилцааг баримтлах хэдий ч Монгол Улсад Монгол хүний зүй ёсны эрх ашгийг дээдлэн эрхэмлэнэ;

8-рт: Ард олны эв нэгдлийг бэхжүүлэн, Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгана;

9-рт: Өвөг дээдсээс уламжлан ирсэн газар нутаг, их түүх, уламжлалт соёл, байгалийн баялгаа хайрлан дээдэлж, эх орны баялаг, түүхий эдийг боловсруулан, баяжуулах үйлдвэрлэлийн бодлогыг хөхиүлэн хөгжүүлнэ;

хэмээн дурдваас,

Өнө эртний өвөг дээдсийн сургаалыг санаж, ташаарсан

алдааг нь давталгүй сургамж хэмээн үзэж, нүүдэлчин удмын суу ухааныг


биширч, өнөө цагийн эрдэмтэн судлаачдаа өргөн дээдэлж, Мөнх Хөх Тэнгэрийн

ивээл дор **МОНГОЛЫН ХҮНИЙ ТӨЛӨӨ НАМ**-ыг үүсгэн байгуулж, даяар улс

олноо зарлан тунхаглав.

УЛААНБААТАР ХОТ

2017 оны 2-р сарын 17-ны өдөр



2. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 2.1. Монголын хүний төлөө намын эрхэм бөгөөд гол зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулийн 19-р зүйлд заасан үүргээ бүрэн биелүүлдэг, ёс зүйтэй төрийг цогцлоон бүрэлдүүлэх явдал юм.
- 2.2. Улсын Их Хурал нь зарчим тогтоон хууль гаргаж, Засгийн газар нь хэрэгжүүлдэг эрүүл тогтолцоог хэрэгжүүлдэг зүй тогтлын дагуу Мөрийн хөтөлбөртөө зарчмын асуудлуудыг тусгаж хэрэгжүүлнэ.
- 2.3. Төрийн тогтвортой, чанартай, зөв, шударга ажиллах нөхцөлийг хангахын тулд Иргэний хяналтын тогтолцоог бүрэлдүүлж бий болгоно.
- 2.4. Улс төр, шүүх, санхүү-эдийн засгийн шинэчлэлийг иж бүрнээр нь хийж улс орноо үсрэнгүй хөгжлийн замд оруулна.
- 2.5. Гишүүдийн тоо, санхүүгийн чадавхиас үл хамаардаг, бодлого боловсруулж хэрэгжүүлэгч улс төрийн намын тогтолцоог бүрэлдүүлэн, улс үндэстэн болон нийтийн өмнө хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх, төрийн үйл ажиллагааг алсын хараатай, ойлгомжтой, үр дүнтэй болгох эрхзүйн болон ёсзүйн тогтолцоог бүрдүүлэхийг эрмэлзэнэ.
- 2.6. Эдийн засгийн бүтцийг оновчтой болгож, нөхөн үрждэг баялагаа арвижуулах, экологийн цэвэр хунсэр тасалдалгүй хангах хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарыг дэмжих бодлогыг боловсруулж ажиллахыг эрмэлзэнэ.
- 2.7. Улсын Их Хурлын гишүүдийн ёс зүй, сахилгын хариуцлага хүлээдэг эрхзүйн үндсийг бүрдүүлнэ.
- 2.8. Гадаадын офшор дансанд гаргасан авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбогдох хөрөнгө, мөнгөйг буцаан авч ирэх хуулийг санаачилан батлуулж хэрэгжүүлнэ.
- 2.9. Нам-Улс төр-Бизнес Нам гэсэн гинжин холбоог таслан зогсоох, институци бүр бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулах эрхзүйн болон ёсзүйн орчныг бүрдүүлэхийн төлөө ажиллана.
- 2.10. Төрийн болоод улс төрийн албан хаагчдын орлогоосоо хэт давсан хэрэглээг хянаж, шалгах хуулийг батлуулж, хэрэгжүүлнэ.
- 2.11. Цөөнх нь хөрөнгөжиж, олонхи нь ядуурдаг зарчмыг халж, Иргэн бүрийг баяжихад саад хийхгүй ч буруу баяжвал өршөөхгүй гэсэн шударга зарчмыг хэрэгжүүлнэ.

3. НИЙГЭМ, ЭРҮҮЛ МЭНД, ХАЛАМЖИЙН БОДЛОГО

- 3.1. Эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх, чийрэгжүүлэх
 - 3.1.1. Өвчин туссан хойно нь эмчлэх биш урьдчилан сэргийлж, хамгаалах бодлогыг чухалчилна.
 - 3.1.2. Нийтийн биеийн тамирыг дэмжиж, шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэх, хот суурин, хорооллын төлөвлөлтөнд цэцэрлэгт хүрээлэн, гүйлт, дугуйн зам, усан сан зэргийг заавал тусгах хууль зүйн орчныг бүрдүүлнэ.
 - 3.1.3. ЭМД-н оновчтой, үр дүнтэй, энэрэнгүй хувилбарыг боловсруулж нэвтрүүлнэ.
- 3.2. Хүн амын өсөлт
 - 3.2.1. Хүн амын өсөлт нь улсын хөгжлийн чухал хэсэг бөгөөд эдийн засгийн эрчимтэй өсөлтийн гол үзүүлэлт гэж үзнэ.



3.2.2. Улсын орны эдийн засгийн чадавхи сайжирч, иргэдийн ирээдүйдээ итгэх итгэл нэмэгдэх нь хүн амын өсөлтөнд сайнаар нөлөөлөх тул урамшууллын **ОНОВЧТОЙ** бодлого нэвтрүүлнэ.

3.3. Ажилгүйдлийг бууруулах бодлого

3.3.1. Ажлын байрыг нэмэгдүүлэх бүхий л боломжийг эрэлхийлж ашиглана /хүүхэд хүмүүжүүлэн, саатуулж, сургадаг цэцэрлэг, сургууль, өдөр өнжүүлэх нь хүүхдийн эцэг эхэд ажил хийх чөлөө зав олгох үүрэгтэй юм/.

3.3.2. Ажлын байр олноор бий болгож, төсвийн ачааллыг багасгадаг жижиг дунд аж ахуйнуудыг татварын хөнгөлөлт, санхүүгийн урамшуулал, дэмжлэгийг нэмэгдүүлэх эрхзүйн орчныг бүрдүүлнэ.

3.3.3. Боловсролын бодлого, мэргэжлийн сургалт, зээлийн бодлого зэрэг нь ажилгүйдлийг багасгахад чиглэгдэх бодлого, зорилгыг хэрэгжүүлэх эрхзүйг таатай орчныг бүрдүүлэхийг төлөө ажиллана.

3.4. Нийгмийн халамж

3.4.1. Нийгмийн халамж нь зорилтот бүлэгтээ чиглэж, хүрч байх бүртгэл тооцооны тогтолцоог бүрдүүлнэ. Халамжийн хавтгайрсан бодлогоос зайлсхийж, бэлэнчлэх сэтгэлгээг багасгана.

3.4.2. Бие дааж амьдрах болон хөдөлмөрлөх чадвар нь хязгаарлагдмал иргэдийг айх аюулгүй, санаа амар амьдрах нийгмийн тогтолцоог хэрэгжүүлнэ.

4. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БОДЛОГО

4.1. Ерөнхий боловсрол

4.1.1. Боловсролын салбар онцгой салбар, онцгой хандлага, бодлого шаардлагатай суурь салбар. Он цагын хэлхээсээр харвал ирээдүйг бүтээгч салбар, бид хэн байх, бид юунд бэлэн байх, бид өрсөлдөх чадвартай эсэх, бид хөгжиж чадах эсэхийг тодорхойлох онцгой өвөрмөц салбар гэдгийг ухааран хандах болно.

4.1.2. Боловсролын салбарыг онцгойлон анхаарах бодлого хэрэгжүүлнэ. Ирээдүйд улс орны хөгжлийг тодорхойлох иргэдийг хүмүүжүүлэх, монголчууд юунд бэлдэх, дэлхийн түвшинд өрсөлдөх чадвартай болгох, цаашдын эрчимтэй хөгжлийг тодорхойлогч салбар хэмээн үзнэ.

4.1.3. Боловсролын тогтолцоог тогтвортой, байнга хөгждөг байдлаар зохион байгуулна. Үндэсний эрдэмтэн мэргэд, багш сурган хүмүүжүүлэгч нарын хүчээр үндэсний онцлогийг харгалзсан боловсролын хөтөлбөрийг боловсруулна. Боловсролын хөтөлбөр нь сургуулийн өмнөх, бага, дунд, ахлах сургуулийн боловсрол, мэргэжлийн, тусгай, дээд боловсролын зэрэг бүх салбар шатлалыг хамарсан шинжлэх ухаанч, цогц бодлого байна.

4.1.4. Боловсролын салбарын хөгжлийн хөшүүрэг нь багш, сурган хүмүүжүүлэгчдийн хөдөлмөрийн үнэлгээ бөгөөд багш, сургагчдын нийгмийн баталгааг сайжруулснаар тэдний нэр хүнд, боловсрол, мэдлэг дээшилж, боловсролтой, соёлтой монгол хүн бэлтгэх тогтолцоо бүрэлдэнэ.

4.1.5. Бүх хүүхэд, залуучуудын суурь боловсрол эзэмших, сурч хүмүүжих орчин ахуйг ижил тэгш, чанартай нөхцөлөөр хангах чиглэлийг барьж ажиллана.

4.1.6. Бидний ирээдүй үеийн хүмүүжил, биеэ авч явах байдал, хүсэл сонирхолд багш нарын жендерийн харьцаа нөлөөлж байгаа гэж үзэж байгаа тул эрэгтэй багш нарын тоог нэмэгдүүлэх үр дүнтэй бодлого хэрэгжүүлнэ.

4.2. Мэргэжлийн сургалт



- 4.2.1. Мэргэжлийн сургалт, боловсролын хандлагад эрс өөрчлөлт гаргана.
- 4.2.2. Мэргэжлийн боловсролтой иргэдэд чадвар, туршлагаа нэмэгдүүлэх, хөгжих, тогтвортой ажлын байртай болоход нь дэмжлэг үзүүлэх бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх талаар судалгаа хийх, эрхзүйн орчныг бүрдүүлэх талаар анхаарч ажиллана..
- 4.2.3. Монгол улсыг үйлдвэрлэгч орон болгоход шаардлагатай инженер, техникч, мэргэжлийн ажилчид бэлтгэх чиглэлд өндөр ач холбогдол өгч, бодлого боловсруулахад анхаарна.
- 4.3. Соёл**
- 4.3.1. Үндэсний соёл нь монгол үндэстний оршин тогтнох, уламжлалт онцлогоо хадгалах нандин дархлаа бөгөөд дэлхий дахинд биднийг таниулах хүчирхэг хэрэгсэл хэмээн үзнэ.
- 4.3.2. Соёл урлаг нь хүн төрөлхтний гоо зүй, гоо сайханы мэдрэхүйг хөглөдөг төдийгүй үндэсний өв уламжлалыг таниулах, эх оронч үзэл, бахарлыг төлөвшүүлэх онцгой салбар гэж үзэн бодлогоор дэмжиж, хөгжүүлэх бодлого баримтална.
- 4.3.3. Кино, драмын урлагийн салбар нь арилжааны чиглэлтэй, зөв хүмүүжил, ёс суртахуун, эх оронч үзэл, үндэсний бахархлыг түгээн дэлгэрүүлэхийг дэмжин ажиллана.
- 4.4. Шинжлэх ухаан**
- 4.4.1. Монгол хэл нь монгол сэтгэлгээний үндэс тул эх хэлээ хамгаалах, зөв дэлгэрүүлэх, хөгжүүлэх бодлого баримтална.
- 4.4.2. Шинжлэх ухаан, туршилт нь дээд боловсролыг сайжруулахын зэрэгцээ шинэ нээлт, технологи, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх шалгуур үзүүлэлтээр үнэлж дэмжинэ.
- 4.4.3. Түүх, археологийн салбарыг аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлэх бодлого баримтална.
- 4.5. Спорт**
- 4.5.1. Нийтийн биеийн тамирыг далайцтай хөгжүүлэх нь бүх нийтийн эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх төдийгүй дэлхийд түвшинд амжилт гаргах авьяаслаг тамирчдыг бэлтгэх суурь хэмээн үзэж, тэдний амжилтаас улбаалан, улс үндэстнээ дэлхий нийтэд сурталчлан, таниулах бодит үйл хэрэг болгоно.
- 4.5.2. Мэргэжлийн болон их спортыг дэмжих бодлого баримтлана.

5. ЭДИЙН ЗАСАГ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГО

- 5.1. Төсөв, санхүү**
- 5.1.1. Эдийн засаг үйлдвэрлэлийн бодлогын шинэчлэл, сайжруулалтын хүрээнд эх орны түүхий эд дээр суурилсан үйлдвэрлэлийг дэмжих, нөхөөн сэргээгдэх баялгийн ашиглалтыг сайжруулах, уул уурхайн өгөөжийг нийтээр шударгаар хүртэх тогтолцоог бий болгоно.
- 5.1.2. Үндэсний мөнгөн тэмдэгтийг долларын түрэмгий нөлөөнөөс хамгаалах, гадаад худалдааны орлого үндэсний банкаар дамждаг тогтолцоог бий болгож хэрэгжүүлнэ.
- 5.1.3. Төсвийн бодлого нь улсын төсөв бүрдүүлэхийн зэрэгцээ дотоодын зах зээл, хүнсний аюулгүй байдлыг давхар хамгаалж байх бодлогыг баримтална.



- 5.1.4. Банк санхүүгийн тогтолцоог эрүүл, ёс зүйтэй шударга болгож, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн таатай нөхцөл бүрдүүлэх чиглэлд ажиллана.
- 5.1.5. Эдийн засаг, үйлдвэрлэлийг дэмжих гаалийн, онцгой, ашгийн татварын зохистой бодлого явуулна.
- 5.2. Хөдөө аж ахуй**
- 5.2.1. Хөдөө аж ахуй, мал аж ахуй, газар тариалан нь улсын хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүн ардын эрүүл, урт наслалтын үндэс гэж үзнэ.
- 5.2.2. Монгол улсын өсөж, үрждэг баялаг болох мал сүргийг үр дүнтэй, зөв зохистой хөгжүүлснээр өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх бөгөөд орон нутагт ажлын байр бий болгох, төсвийн орлогыг нэмэгдүүлэх эх үүсвэр хэмээн үзэж дэмжиж ажиллана.
- 5.2.3. Нүүдлийн мал аж ахуй нь эрчимжүүлсэн мал аж ахуйтай зэрэгцэн хөгжиж, давуу талаа илэрхийлэн өрсөлдөх ёстой уламжлалт суурь салбар мөн гэж үзнэ.
- 5.2.4. Мал эмнэлэгийн нэгдсэн бодлого, нэгдсэн мэдээлэл, нэгдсэн хяналт, нэгдсэн хангалт, нэгдсэн сүлжээгээр мал сүргийг эрүүл байлгаж дотоодын болон экспортын чанар шаардлага хангана.
- 5.2.5. Малчин-үйлдвэрлэгч-борлуулагч гэсэн хамтарсан хэлбэрээр ажиллах хоршооллын бодлогыг дэмжинэ.
- 5.3. Газар тариалан**
- 5.3.1. Тариалангийн аж ахуй нь улсын хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүн ардын эрүүл, урт наслалтын үндэс гэж үзнэ.
- 5.3.2. Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 5.4. Аж үйлдвэр**
- 5.4.1. Дэлхийн нийт хэрэглэний зах зээлийн 25%-ийг бүрдүүлдэг том гүрнүүдийн дунд оршдог давуу талаа ашиглан үйлдвэрлэгч, экспортлогч улс болох бүрэн боломжтой гэж үзнэ.
- 5.4.2. Дотоодын түүхий эдийн үйлдвэрлэл, боловсруулалтыг түлхүү дэмжинэ.
- 5.4.3. Байгальд хор хөнөөлгүй, технологийн дэвшилтэт үйлдвэрүүдэд дэмжлэг үзүүлнэ.
- 5.5. Худалдаачид нь нийгмийн эрчимтэй хөгжилд томоохон хувь нэмэр оруулдаг бөгөөд зах зээлийг соргогоор мэдэрч зохицуулах, судлах, үйлдвэрлэл хөгжүүлэх томоохон хүчин болохын хувьд үйл ажиллагааг нь дэмжиж, борлуулалтыг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 5.6. Уул уурхай**
- 5.6.1. Байгалийн бүх баялаг ард түмний өмч гэсэн Монгол улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалаар хариуцлагатай уул уурхайн хөгжлийг зохицуулна.
- 5.6.2. Хэт олон тооны, замбараагүй, үр ашиг нь тодорхойгүй, хууль зөрчсөн /гол мөрний ай сав, ус ундарга, бэлчээр, ард түмний уламжлалт шүтлэг бүхий газар нутаг бохирдуулсан/ уурхайнуудыг цэгцэлнэ.
- 5.7. Эрчим хүч**
- 5.7.1. Эрчим хүчний үйлдвэрлэл, түгээлт, борлуулалтанд төрийн мэдлийг 50%-иас доош буулгахгүй байх стратегийн бодлого баримтлана.



5.7.2. Бүх төрлийн эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжих ба сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэл баримтлана.

5.7.3. Улс орныг хөгжүүлэхэд хангалттай эрчим хүч үйлдвэрлэх ба эрчим хүчний салбарыг экспортын орлого бүрдүүлэх томоохон эх үүсвэр гэж үзнэ.

5.8. Зам тээвэр, дэд бүтэц

5.8.1. Өргөн уудам нутагт тохиромжтой тээврийн салбарыг дэмжиж ажиллана.

5.8.2. Ард нийтийн ая тухтай амьдрах эрхийг хангах зорилгоор хот суурин газруудын тухайн нөхцөлд нь тохиромжтой инженерийн дэд бүтцүүдийг байгуулахыг эрмэлзэнэ.

5.9. Барилга, хот байгуулалт

5.9.1. Хот суурингийн төлөвлөлтийг сайжруулж, холбогдох чанар стандартыг батлан хэрэгжүүлж ажиллана.

5.9.2. Амины орон сууцтай болох дэд бүтцийг хөгжүүлж бүтээлч дунд давхарга нь өөрийн байшинд тухтай амьдардаг дэлхийн жишгийг хэрэгжүүлнэ.

5.10. Аялал жуулчлал

5.10.1. Аялал жуулчлал нь ажлын байр олноор үүсгэдэг, соёлын болон бусад харилцааг хөгжүүлдэг чухал салбар хэмээж сайшаан дэмжинэ.

6. ТӨРИЙН БАЙГУУЛАЛТ, ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГО

6.1. Улс төрийн шинэчлэл

6.1.1. Улс төрийн намуудыг хатуу гишүүнчлэлгүй, бодлогын байгууллага болгосноор бүх салбарт буй улс төрийн оролцоо арилах ба намын гишүүнээ л дэмждэг гаж тогтолцоог халж, чадвартай, мэдлэгтэй боловсон хүчин үнэлэгддэг нөхцлийг бүрдүүлнэ.

6.2. Төрийн алба

6.2.1. Төрийн албыг чадварлаг, цомхон байлгах бодлого баримталж, Монгол төрийн бахархалыг бүрдүүлнэ.

6.2.2. Төрийн алба нь Үндсэн хуульд заасан зарчмын дагуу, Үндсэн хуульд заасан үүргээ гүйцэтгэдэг иж бүрдэл байх ёстойг чухалчилна.

6.3. Засгийн газрын бүтэц, үүрэг

6.3.1. Төрийн албыг чадварлаг, мэргэшсэн, тогтвортой ажилладаг цомхон бүрэлдэхүүнтэй, бүтээмж сайтай байхаар зохион байгуулахыг эрмэлзэнэ.


6.4. Хяналтын тогтолцоо

6.4.1. Төрийн бүх байгууллагууд үнэнч шударга, алдаагүй, зөв зохистой ажиллах үндсэн нөхцөл нь хараат бус, хөндлөнгийн хяналт, хариуцлагын тогтолцоо гэж үзнэ.

6.4.2. Хүний эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн хууль эрх зүйг сахиулдаг иргэний хяналтын тогтолцоог байгуулна.

6.5. Шүүх засаглал

6.5.1. Бүх шатны шүүгчид нь хараат бусаар, шударгаар ажиллах боломжтой шүүхийн тогтолцоог бий болгох хууль эрхзүйн орчинг бүрдүүлнэ.



6.5.2. Шүүхийн байгууллагыг шударга, тэнцвэртэй байлгах зорилгоор төрийн төлөөлөл болох шүүгч нь ардын төлөөлөгчтэй хамтран, хараат бус, шударга шийдвэр гаргадаг байх эрхзүйн орчинг бүрдүүлнэ.

6.5.3. Шүүхийн байгууллагыг шударга, тэнцвэртэй байлгах зорилгоор төрийн төлөөлөл болох шүүгч нь ардын төлөөлөгчтэй хамтран, хараат бус, шударга шийдвэр гаргадаг байх эрхзүйн орчинг бүрдүүлнэ.

6.5.4. Хүн өөрийгөө болон бусдыг өмгөөлөх эрхийг чөлөөтэй болгож нээнэ.

6.6. Хүчний байгууллагын шинэчлэл

6.6.1. Хууль хяналтын байгууллагууд “Гүйцэтгэл – цагдаа, хяналт – прокурор, шийдвэр – шүүх” гэсэн схемийн дагуу хараат бус, шударгаар үйл ажиллагаа явуулдаг байх хууль эрхзүйн таатай орчинг бүрдүүлэхийн төлөө ажиллана.

7. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

7.1. Батлан хамгаалах

7.1.1. Хугацаат цэргийн алба нь батлан хамгаалахын үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ залуучуудыг эх орон сэтгэлтэй, бие бялдар, хүмүүжлийн өв тэгш хөгжилтэй, хамтран ажиллах чадвартай, бүтээн байгуулах тэмүүлэлтэй болгох сургалт хүмүүжлийн оновчтой хөтөлбөр байхаар хэрэгжүүлнэ.

7.2. Гадаад харилцаа

7.2.1. Төвийг сахих, эвсэлд үл нэгдэх, цөмийн зэвсэггүй бүс байх уламжлалт бодлогоо баримтлахыг чухалчилна.

7.2.2. Дипломат харилцаа нь аюулгүй байдал, тусгаар тогтнолыг хангах, бүх салбар дахь харилцааг дэмжих, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой ажиллана.

7.2.3. Дэлхийн аль ч улсад Монгол улсын иргэний эрхийг хангах, хамгаалах бодлогыг баримтлана.

7.3. Гадаадын хөрөнгө оруулалт

7.3.1. Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж дэлхийн түвшинд дүйцүүлэх гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

7.3.2. Дотоодын зах зээлд хамгаалах шаардлагатай чухал салбарыг тодорхойлж, уг салбарт гадаадын хөрөнгө оруулагчдын хэт давамгайл байдлыг хязгаарлана.

7.4. Гадаад худалдаа

7.4.1. Мөнхийн 2 хөрштэйгээ харилцан ашигтай, оновчтой харилцаа, худалдааны бодлогыг баримталж харьцана.

7.4.2. Гадаад худалдааны гэрээ, бодлогоор дотоод үйлдвэрлэлээ хөгжүүлэх чиглэл, захиалга хийдэг тогтолцоог үүсгэнэ.


< ----- >



2024-2028 онуудад хэрэгжүүлэн ажиллах үндсэн хөтөлбөр

1. Төсөв санхүү эдийн засгийн яам
2. Хууль зүй, дотоод хэргийн яам
3. Гадаад хэргийн яам – гадаад харилцаа, гадаад худалдаа
4. Байгалийн баялаг экологийн яам
5. Батлан хамгаалах яам
6. Эрүүлийг хамгаалах, нийгмийн халамжийн яам
7. Гэгээрлийн яам – боловсрол, соёл урлаг, шинжлэх ухааны салбар
8. Дэд бүтцийн яам – эрчим хүч, тээвэр, барилга
9. Аж үйлдвэрлэлийн яам

1. Төсөв санхүү эдийн засгийн яам
 - a. Татвар
 - b. Гааль
 - c. Төсөв
 - d. Банк
2. Хууль зүй, дотоод хэргийн яам
 - a. Иргэний хяналтын тогтолцоог хуульчлах
 - b. Шүүхийн тогтолцооны өөрчлөлт, шинэчлэл
 - c. Шинэ хууль боловсруулах
 - d. Хуучин хуулийн хэрэглээ хэрэгцээг дүгнэх
 - e. Хууль сурталчлах
 - f. Дэг журам, сахилга бат
3. Гадаад хэргийн яам – гадаад харилцаа, гадаад худалдаа
 - a. Дипломат гадаад харилцаа
 - b. Гадаад худалдаа
4. Байгалийн баялаг экологийн яам
 - a. Байгалийн баялгийн сан
 - b. Монгол алт сан
 - c. Экологи нөхөн сэргээлт
 - d. Ойжуулалт, ойн аж ахуй
 - e. Ус хамгаалал
 - f. Аялал жуулчлал
5. Батлан хамгаалах яам
 - a. Хилийн цэрэг
 - b. Зэвсэгт хүчин – цэрэг эх оронч хүмүүжлийн цогц
6. Эрүүлийг хамгаалах, нийгмийн халамжийн яам
 - a. Эрүүл мэнд
 - b. Нийгмийн халамж
 - c. Хөдөлмөр хамгаалал
7. Гэгээрлийн яам – боловсрол, соёл урлаг, шинжлэх ухааны салбар
 - a. Шинжлэх ухаан
 - b. Соёл урлаг
 - c. Сонгодог урлаг
 - d. Урлаг – үзэл суртал, хүмүүжлийн хэрэгсэл
 - e. Боловсрол
 - f. Сургуулийн өмнөх боловсрол
 - g. Ерөнхий боловсрол
 - h. Мэргэжлийн ба тусгай боловсрол
 - i. Дээд сургууль



A handwritten signature in black ink, located at the bottom center of the page.

8. Дэд бүтцийн яам – эрчим хүч, тээвэр, барилга
 - a. Эрчим хүч – хөгжлийн суурь хангамж
 - b. Тээвэр – эдийн засгийн хөгжлийн судас
 - c. Барилга – стандарт гаргах, сүйцэтгэлийн хувийн хэвшил
9. Аж үйлдвэрлэлийн яам
 - a. Хөдөө аж ахуй
 - b. ХАА-н түүхий эд дээр суурилсан үйлдвэрлэл
 - c. Газар тариалан, хүнсний ногоо
 - d. Газар тариалангийн бүтээгдэхүүн дээр суурилсан үйлдвэрлэл
 - e. Оюуны бүтээл дээр суурилсан үйлдвэрлэл
 - f. Машин тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл
 - g. Газрын баялагт суурилсан үйлдвэрлэл
 - h. Аялал жуулчлал

